

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар
сарын 11-ны өдрийн 5/130 дугаар тушаалын
дүгээр хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

№	Газар, хэлтсийн нэр	Чиг үүрэг
1	Төрийн захиргааны удирдлагын газар	✓ Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах; ✓ яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтийг зохион байгуулах; ✓ салбарын ажиллах хүч, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох, судалгаа хийх, судалгааны үр дүнгээр яамны нэгж, удирдлага, бусад дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах; ✓ салбарын төрийн албан хаагчдын хэрэгцээг тодорхойлох, хэтийн болон ойрын бодлогын хувилбар боловсруулах, чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах асуудлыг зохион байгуулах; ✓ салбарын инженер, техникийн ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах асуудлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангах; ✓ барилгын салбарын хамтын хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих; ✓ Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хүний эрхийн асуудал болон яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл болон аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах, гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулах, дайчилгааны асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцах, салбарын бодлогод тусгуулах; ✓ салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, сайдын гадаад, дотоод айлчлалыг зохион байгуулах; ✓ төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний гүйцэтгэлийг хангуулах; ✓ иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих; ✓ сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, үр дүнг танилцуулах; ✓ яамны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах; ✓ салбарын шагнал олгох асуудлыг зохион байгуулах;

	✓ яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах асуудлыг зохион байгуулах; ✓ салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх; ✓ удирдлага, яамны аппаратын албан хаагчдыг шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах; ✓ байгууллагын нууцын асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцан, Төрийн нууцын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; ✓ салбарын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах; ✓ яамны архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль тогтоомж, стандарт, заавар журмын хүрээнд хөтлөх, эрхлэн явуулах; ✓ Улсын Их Хурал, Засгийн газар, бусад төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудтай харилцах ажлыг зохион байгуулах, шаардлагатай зөвлөгөө, мэдээллээр хангах; ✓ яамны дотоод үйл ажиллагааг зохион байгуулах; ✓ Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагаас цаг үеийн шинжтэй тухай бүр гарсан шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан ажиллах, биелэлтийг хангах, дэмжлэг туслалцаа үзүүлэх, бусад нэгжтэй хамтран ажиллах, мөн яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах. ✓ Салбарын суурь судалгаа, статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулж, мэдээллийн сан бүрдүүлэх, салбарын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх; ✓ салбарын статистикийн мэдээллийг сайжруулж, бүртгэл мэдээллийн маягтын дагуу салбарын мэдээлэл, судалгааг гаргуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; ✓ салбарын төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудтай чиг үүргийн дагуу хамтран ажиллах, бодлогын чиглэл, удирдамжаар хангах, судалгаа, мэдээ, мэдээллийг түргэн шуурхай авч, мэдээлэл солилцож ажиллах; ✓ Үндэсний статистикийн хороотой хамтран ажиллах, судалгаа хийх, нэгтгэх, харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх; ✓ салбарын үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулах, цахим засаглалыг нэвтрүүлж, мэдээллийн технологийг хөгжүүлэх, цахимжуулалтын талаар салбарын бодлого, төлөвлөлтийг нэгдсэн удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх; ✓ мэдээллийн технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа оновчтой ашиглах замаар салбарын үйлчилгээг илүү үр ашигтай, мэдээллийг ил тод, хүртээмжтэй болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэд мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлэх;
--	---

		✓ салбарын мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн санг үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын найдвартай байдлыг хангах; ✓ шаардлагатай бусад мэдээллийн сан, программ хангамжийн хөгжүүлэлтийг хийж хэрэглээнд нэвтрүүлэх замаар яамны сүлжээ, техник, программ хангамж, системийн хэвийн, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах;
	Хуулийн хэлтэс	✓ Салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах, салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх; ✓ Улсын Их Хурал, Засгийн газар, бусад яамтай хамтран болон дангаараа шийдвэрлэх асуудлыг боловсруулахад санал өгөх, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, удирдлагыг мэдээллээр хангах; ✓ хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн бүртгэл хөтлөх; ✓ Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төсөл боловсруулахад хууль зүйн зөвлөгөө өгөх, тушаалын төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, дугаар олгох; ✓ гэрээ, хэлэлцээр, бусад эрх зүйн баримт бичиг, салбарын норм дүрэм, стандартыг боловсронгуй болгоход санал өгөх, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; ✓ яамны бүтцийн нэгжүүдээс бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид явуулж байгаа албан бичгийн хууль зүйн үндэслэлийг хянах, хууль зүйн зөвлөгөө өгөх; ✓ хариуцсан салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах талаар шаардлагатай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулахад болон хууль тогтоомжийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх; ✓ хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг сурталчлахад оролцох; ✓ УИХ, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг нэгтгэж, саналыг хүргүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах; ✓ яамны хууль ёсны эрх ашгийг итгэмжлэлийн үндсэн дээр хууль, шүүхийн байгууллагад төлөөлөх; ✓ шүүхийн маргааны бүртгэл хөтөлж, удирдлагад танилцуулан, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах; ✓ дайчилгааны асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцах; ✓ яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах.

	Гадаад хамтын ажиллагааны хэлтэс	✓ Гадаад хамтын ажиллагааны бодлого, чиглэлийг салбарын үйл ажиллагааны стратегитай уялдуулан тодорхойлох, хамтын ажиллагааг өргөжүүлэх хөгжүүлэх, удирдан зохион байгуулах, төлөвлөгөө гаргах; ✓ салбарын гадаад хамтын ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, гадаад арга хэмжээ, чиглэлийг нэг цонхны бодлогын хүрээнд баримтлан нэгдсэн байдлаар зохион байгуулж, хариуцан ажиллах; ✓ Засгийн газар хоорондын комиссын хуралдаанууд, зөвлөлдөх болон дугуй ширээний уулзалтууд, дээд, өндөр түвшний айлчлалууд, стратегийн түншлэлийн хөтөлбөр, хамтын ажиллагааны урт, дунд хугацааны хөтөлбөрүүд, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр зэрэг хоёр болон олон тал хамтын ажиллагааны механизмуудад салбарын хамтын ажиллагааны саналыг тухай бүрд хэлэлцүүлэх, тусгуулах ажилд дэмжлэг үзүүлэх; ✓ хоёр болон олон талт хамтын ажиллагааг салбарын стратегитай уялдуулан хөгжүүлэх, төсөл хөтөлбөрүүдийн саналыг орчуулахад дэмжлэг үзүүлэх; ✓ гадаад төрийн байгууллагуудтай хийх хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ хэлэлцээрийг холбогдох журмын дагуу зохион байгуулж, нэгдсэн мэдээллийн санд бүртгэх; ✓ яамны чиг үүрэгтэй уялдуулан гадаадын сайн туршлагыг судалж, энэ талаар мэдээлэл гаргаж ажиллах; ✓ яам, харьяа байгууллагуудын удирдлагуудын айлчлал, протокол, уулзалтууд, албан хаагчдыг гадаад томилолтыг нэгдсэн байдлаар зохион байгуулах; ✓ яамны захиалгаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг салбарын бодлогод нийцүүлэн нэгтгэх, хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох, хөрөнгө оруулалт татах, нэг цонхны бодлоготой уялдуулан холбогдох яамтай хамтран шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах; ✓ гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төслүүдийн Монголын талын хөрөнгө (улсын төсөв), гадаадын зээл, тусламжийн төсвийн төлөвлөлтийг боловсруулж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалтад хяналт тавих, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн удирдлага, ажилтнуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах; ✓ яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах.
2	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	✓ Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын бодлого, стратеги төлөвлөгөө, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүү, хөрөнгө оруулалтын нэгдсэн удирдлагаар хангах; ✓ Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, холбогдох журмын дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын бодлого, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсвийг төлөвлөхөд мэргэжлийн арга зүй, зохион байгуулалтаар хангах;

		✓ Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хуульд нийцүүлэн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг хангах; ✓ хөрөнгө оруулалтын оновчтой, үр дүнтэй байдлыг хангах чиглэлээр бусад салбар болон орон нутгийн уялдааг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах; ✓ төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын хөтөлбөр, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг хянах, сайдын багцын төсвийн төлөвлөлтөд нэгтгэх; ✓ төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг хийж, батлуулах; ✓ төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих; ✓ төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянах, санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах, удирдлага зохицуулалтаар хангах; ✓ төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан хөрөнгийн болон урсгал төсвийг зарцуулах, тайлагнах; ✓ төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын хөрөнгө оруулалтын судалгаа, мэдээ тайлангаар яамны удирдлага болон холбогдох байгууллагыг хангах; ✓ төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж, аудит хийлгэн баталгаажуулж, тайлагнах ажлыг зохион байгуулах; ✓ төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд аудит хийлгэн баталгаажуулах ажлыг зохион байгуулах; ✓ яамны урсгал зардлыг батлагдсан төсвийн дагуу үр ашигтай зарцуулах, санхүүгийн тайланг улирлаар, хагас, бүтэн жилээр тайлагнах, жилийн эцсийн тайланд аудит хийлгэн баталгаажуулах ажлыг зохион байгуулах; ✓ төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын төрийн сангийн өдөр тутмын гүйлгээг хянан баталгаажуулах, холбогдох мэдээ тайланг нэгтгэх, хүргүүлэх; ✓ төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгийг зохих өмчлөлд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, ашиглалт, бүртгэлийг хянаж тайлагнах; ✓ яамны эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, төрийн өмчийн ашиглалт, хадгалалтад, хамгаалалтад хяналт тавих, тайлагнах; ✓ яамны урсгал үйл ажиллагааны худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах; ✓ яамны албан хаагчдын цалин, түүнтэй холбоотой олговор, татвар хураамж, нийгмийн даатгалын шимтгэлийг хугацаанд нь үнэн зөв тайлагнах; ✓ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, санхүүгийн мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулж, иргэдэд ил тод мэдээлэх;
--	--	--

		✓ Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагаас цаг үеийн шинжтэй тухай бүр гарсан санхүүтэй холбогдох шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан ажиллах, биелэлтийг хангах, дэмжлэг тусалцаа үзүүлэх, бусад нэгжтэй хамтран ажиллах, яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах.
3	Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар	✓ Төрөөс баримтлах урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд хот байгуулалт, орон сууцжуулалтын салбарын чиглэлээр тусгуулах санал, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх, тайлагнах; ✓ Хот байгуулалтын тухай хууль, хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах; ✓ хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдамж, мэргэжил, арга зүйн зохицуулалтаар хангах, зохион байгуулах, бусад салбартай ажлын уялдааг ханган хамтран ажиллах; ✓ хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах; ✓ хот, тосгоны, төлөвлөлт, архитектур, ландшафт, ногоон байгууламж, хот, тосгоны орон зайн дүр төрхийг тодорхойлох чиглэлээр төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдамж, чиглэл, зохицуулалт, зөвлөгөө дэмжлэгээр хангах, үнэлэлт, дүгнэлт өгөх; ✓ “Ухаалаг”, “Тогтвортой” хөгжлийн загварыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; ✓ хот байгуулалт, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө бусад үе шатны баримт бичгүүдийг төрөөс баримтлах урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, харилцан уялдааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих; ✓ хот байгуулалтын кадастрыг эрхлэх, мэдээллийн системийг хөгжүүлэх, хүн амын амьдрах орчны чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх; ✓ хот байгуулалтын баримт бичигт улсын экспертизийн дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах; ✓ орон сууцны эрх зүйн орчинг бүрдүүлэх, санхүүжилтийн бодлого боловсруулах, төлөвлөлт, төсөл, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах; ✓ салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн талаар Улсын Их Хурал, Засгийн газар, яамд, бусад холбогдох байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хамтран ажиллах;

		✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан орон сууцны талаарх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх; ✓ орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн тогтолцоог боловсруулах, оролцогч байгууллагуудын уялдааг хангах, хэрэгжилтийг зохион байгуулах; ✓ түрээсийн орон сууцны тогтолцоог сайжруулах, түрээсийн орон сууцны санг төр, хувийн хэвшлийн оролцоотой нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны асуудал эрхэлсэн байгууллагыг удирдлага, арга зүйгээр хангах; ✓ төрөөс иргэдийг хямд өртөгтэй орон сууцаар хангах төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах; ✓ аймаг, нийслэл хотын ерөнхий архитекторуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах; ✓ хот, тосгоны нутаг дэвсгэрийн ашиглалт, хүрээлэн буй орчны төлөв байдал, инженерийн шугам сүлжээний хангамжийн түвшин, барилга байгууламж, байр зүйн зураглал, мэдээллийн хот байгуулалтын кадастрын нэгдмэл мэдээллийн санг “Орон зайн өгөгдөл, мэдээллийн “Геоплатформ” нэгдсэн систем”-тэй уялдуулан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжлийн удирдамж, чиглэл, зохицуулалт, зөвлөгөө дэмжлэгээр хангах; ✓ хуулийн этгээдэд хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналт, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтоохтой холбогдох асуудлыг зохион байгуулах; ✓ хот байгуулалт, төлөвлөлтийн чиглэлээр боловсон хүчин, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх; ✓ салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд олон улсын тэргүүн туршлага, арга зүй, аргачлалыг судлах, өөрийн оронд нэвтрүүлж, нутагшуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах; ✓ олон нийтийн оролцоо, орчин үеийн техник, технологид суурилсан “ухаалаг”, “тогтвортой” хот, тосгоныг шинээр төлөвлөх, байгуулах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, энэ талаар сургалт зохион байгуулах; ✓ салбарын бодлого, үйл ажиллагаатай төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, салбар дундын зохицуулалтыг хангах; ✓ удирдах дээд байгууллага, удирдлагын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад удирдамж, зохицуулалт, зөвлөгөө, дэмжлэгээр хангах; ✓ Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагаас цаг үеийн шинжтэй тухай бүр гарсан шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан ажиллах, биелэлтийг хангах, дэмжлэг туслалцаа үзүүлэх, бусад
--	--	---

		нэгжтэй хамтран ажиллах, мөн яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах.
3.1	Хот дахин төлөвлөлтийн хэлтэс	✓ Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах; ✓ хот, суурин газрыг дахин хөгжүүлэх талаарх хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; ✓ архитектур, хот байгуулалт, төлөвлөлт, барилга байгууламжид тавигдах шаардлагад нийцүүлэн хот, суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах; ✓ иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хот, суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулахад (барилгын үйл ажиллагаанаас өмнөх) чиглэсэн нутаг дэвсгэр, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагааг хангах; ✓ хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд инженерийн дэд бүтцийн төлөвлөлтөд шаардлагатай суурь судалгаа, мэдээллийг гаргуулахад инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан нэгжтэй хамтран ажиллах; ✓ хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны инженерийн дэд бүтцийг төлөвлөхөд бодлогын чиглэл, мэргэжлийн удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд оролцогч байгууллагуудын уялдааг хангах; ✓ Хот суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан үүсэх газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөх олговрын талаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нөлөөллийн судалгаа, үнэлгээ хийх, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах; ✓ хот, суурин газрыг шинэчлэн зохион байгуулах судалгаа, төлөвлөлтийг боловсруулах, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах; ✓ хот, тосгоны газрын үнэлгээ, төлбөр, татвар, эдийн засгийн судалгаа, тооцоолол, төлөвлөлтийг хийх;

		✓ салбарын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд төрийн болон нутгийн захиргаа, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, нэгдсэн удирдамж, чиглэл, салбар дундын зохицуулалтаар хангах, дэмжлэг үзүүлэх; ✓ хот, суурин газрыг дахин хөгжүүлэх талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, норм, стандартыг сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулах; ✓ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах, хяналт тавих. ✓ салбарын институтийг бэхжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, чадавхыг хөгжүүлэхтэй холбогдсон бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах; ✓ удирдах дээд байгууллага, удирдлагын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад удирдамж, зохицуулалт, зөвлөгөө, дэмжлэгээр хангах; ✓ яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах.
4	Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар	✓ Нийтийн аж ахуй, орон сууц ашиглалт, инженерийн дэд бүтцийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох; ✓ Салбарын урт, дунд хугацааны бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулах, төлөвлөх, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, удирдлагаар хангах, хяналт тавих; ✓ Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын улсын төсөв, гадаадын зээл тусламжаар салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; ✓ Хот, суурин газарт ус хангамж, ариутгах татуурга, ариун цэврийн байгууламж болон цэвэрлэх байгуулам, төвлөрсөн дулаан хангамжийн системийг бий болгож, хөгжүүлэх, тогтворжуулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах; ✓ Салбарын норм, нормативын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулах, батлуулах ажлыг мэргэжлийн удирдлага зохицуулалтаар хангах; ✓ Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшил дээшлүүлэх, чадавх бэхжүүлэх, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр боловсруулж, бодлого зохицуулалтаар хангах; ✓ Инженерийн дэд бүтцийг шинээр төлөвлөх болон шинэчлэх төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлого, зохицуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; ✓ Нийтийн аж ахуйн салбарын бодлогыг засаг захиргааны бүх нэгжид нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах, ; ✓ Нийтийн аж ахуйн салбарт шинжлэх ухааны ололт, дэвшилтэд техник, технологи, инновацыг нэвтрүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх;

		✓ Салбарын төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын засаглалыг ил, тод, нээлттэй болгон бэхжүүлэх, төгөлдөржүүлэх, төрийн бус байгууллага, аймаг, орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах; ✓ Салбарын хэмжээнд гадаад хамтын ажиллагааны санал боловсруулах, холбогдох арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; ✓ Салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах; ✓ Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагаас цаг үеийн шинжтэй тухай бүр гарсан шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан ажиллах, биелэлтийг хангах, дэмжлэг туслалцаа үзүүлэх, бусад нэгжтэй хамтран ажиллах, мөн яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах.
4.1	Инженерийн дэд бүтцийн хэлтэс	✓ Салбарын бодлого боловсруулахад шаардлагатай тооцоо, судалгаа хийж, санал боловсруулах ажлыг зохион байгуулах; ✓ Бодлогын баримт бичгүүдэд тусгасан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага, зохицуулалтаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг тайлагнах; ✓ Инженерийн дэд бүтцийн норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох, төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах; ✓ Салбарын суурь судалгаа, мэдээллийг бүрдүүлэх, баяжуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн сан бүрдүүлж боловсронгуй болгох, удирдлага, дээд шатны байгууллага, иргэдийг мэдээллээр хангах; ✓ Инженерийн дэд бүтцийн чиглэлээр шинжлэх ухааны ололт, дэвшилтэд техник, технологи, инновацыг судлан нэвтрүүлэх, тэдгээрийг ашиглах, нутагшуулах, энэ чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх; ✓ Инженерийн дэд бүтцийн техник, технологийн шинэчлэлтийн санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар шийдвэрлүүлэх тооцоо, судалгаа хийж санал боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх; ✓ Улсын төсөв, гадаадын зээл тусламжаар салбарт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийн тайлан мэдээг гаргах, танилцуулах; ✓ Инженерийн дэд бүтцийн асуудал эрхэлсэн төрийн болон нутгийн удирдлагын байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, бодлогын чиглэл, мэргэжлийн удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; ✓ Салбарын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх санал боловсруулах, тайлагнах;

		✓ Хот, суурин газрын үерийн эрсдэлийн үнэлгээ, инженерийн бэлтгэл арга хэмжээний дунд хугацааны /мастер/ төлөвлөгөөг шинээр болон шинэчлэн боловсруулахад удирдлага зохицуулалтаар хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх; ✓ Яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах.
5	Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар	✓ Барилга, барилгын материал (цаашид “салбарын” гэх)-ын талаар баримтлах бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх; ✓ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын төсөл боловсруулах, боловсронгуй болгох ажлын хэрэгжилтийг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах; ✓ уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр салбарын эрх зүйн орчныг сайжруулах, хамтран ажиллах, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; ✓ тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн ногоон, хот суурин, барилга байгууламж болон хүлэмжийн хийн ялгарал багатай (асуудал хариуцсан холбогдох нэгжтэй хамтран), эрчим хүчний хэмнэлттэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн инновац техник-технологийг нэвтрүүлэх, бодлого тодорхойлох, төлөвлөх; ✓ салбарын шинжлэх ухаан, техник, технологийн дэвшилтэт арга, инновац, технологийн олслтыг өөрийн оронд нэвтрүүлэх, нутагшуулах ажлыг зохион байгуулах, бодлогын баримт бичиг болон төсөл, хөтөлбөрт тусгуулах; ✓ салбарын норм, нормативын тогтолцоог бүрдүүлэх, олон улсын туршлага судлах, нэвтрүүлэх, нутагшуулах, стандарт, норм нормативын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, тэдгээрийг сурталчлах; ✓ барилга байгууламжийн норм, нормативын санг бүрдүүлэх, зарцуулах болон сангийн үйл ажиллагааг бодлогын удирдамж, чиглэлээр хангах; ✓ салбарт шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн тооцоо судалгаа хийх, санал боловсруулахад мэргэжлийн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохицуулах; ✓ барилгын салбарын үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх, цахимжуулах ажилд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, мэдээллээр хангах; ✓ барилга байгууламжийн зураг төсөл, чанар аюулгүй байдал, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, ашиглалт, барилгын салбарын төсөв, үнэ бүрдэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах; ✓ барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үе шатыг олон улсын жишигт хүргэх, улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах даалгаварт санал өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх; ✓ барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын чанарын хяналтын тогтолцоог сайжруулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

		✓ барилга, барилгын материалын салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангах, харьяа байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, удирдамжаар чиглүүлэх, хэрэгжилтийг хангуулах; ✓ олон улсын стандарт, норм нормативын баримт бичгийг өөрийн оронд нэвтрүүлэх, нутагшуулах замаар салбарын норм, нормативын тогтолцоог сайжруулах ажлыг зохион байгуулах, сурталчлах; ✓ ногоон барилгын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ дэвшилтэт материал, бүтээгдэхүүн, хүлэмжийн хийн ялгарал багатай, эрчим хүчний хэмнэлттэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн техник, технологи, инновацын талаар бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх; ✓ ногоон барилгын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн инновац, техник-технологийн судалгаа хийх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах /эрчим хүч, ус, барилгын материал/; ✓ салбарын суурь судалгаа, хэрэгжиж буй бодлого, төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллээр удирдлага, дээд шатны байгууллага, хуулийн этгээд, иргэдийг хангах; ✓ газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэрлэх чадварыг сайжруулах чиглэлээр салбарын болон холбогдох хууль тогтоомж, бодлого, төсөл, хөтөлбөрийг боловсруулахад төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах; ✓ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, салбар хорооны үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах; ✓ салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын сайн туршлага, арга зүй, аргачлалыг судлах, өөрийн оронд нэвтрүүлж, нутагшуулах ажлыг холбогдох нэгж, байгууллагатай хамтран зохион байгуулах; ✓ гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн дэргэдэх “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах байнгын ажиллагаатай дэд зөвлөл”-ийн төлөвлөгөөг боловсруулахад мэргэжил арга зүй туслалцаа үзүүлж, хэрэгжилтийг хангах; ✓ барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, удирдамжаар чиглүүлэх, хэрэгжилтийг хангуулах; ✓ барилгын салбарт зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх замаар хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгох үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах; ✓ барилгын материалын сорилт шинжилгээний лабораториудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;
--	--	--

		✓ барилгын салбарт барилгын мэдээлэлтэй загварчлал (BIM)-ыг нэвтрүүлэх бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангуулах; ✓ FIDIC-ын гэрээг барилгын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах; ✓ барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг олон улсын түвшинд хүргэх ажлыг зохион байгуулж ажиллах; ✓ Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагаас цаг үеийн шинжтэй тухай бүр гарсан шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан ажиллах, биелэлтийг хангах, дэмжлэг тусалцаа үзүүлэх, бусад нэгжтэй хамтран ажиллах, мөн яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах; ✓ яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах.
5.1	Материал үйлдвэрлэлийн хэлтэс	✓ Барилгын материалын үйлдвэрлэл, импорт, ханган нийлүүлэлт, экспортын бодлого, чанар, хяналтын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах; ✓ барилгын материал үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангуулах, ✓ барилгын материалын ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох замаар барилгын материалын импортыг бууруулах, экспортод гаргах бүтээгдэхүүний боломжийг судлах, зохицуулах; ✓ эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологи үйлдвэрлэлийг дэмжиж, шинэ материал, бүтээгдэхүүн бий болгох ажлын хэрэгжилтийг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах; ✓ барилгын материалын суурь судалгаа, мэдээллийг бүрдүүлэх, баяжуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, боловсронгуй болгох, удирдлага, дээд шатны байгууллага, иргэд, ААНБ-ыг мэдээллээр хангах; ✓ барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, барилгын материал үйлдвэрлэгч байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, удирдамжаар чиглүүлэх, хэрэгжилтийг хангуулах, зохицуулах; ✓ барилгын материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдамжаар чиглүүлэх, хэрэгжилтийг хангуулах, зохицуулах; ✓ түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалт, уул уурхай, эрчим хүчний салбарын хаягдлыг барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах талаар санал боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

		✓ барилга байгууламжийн хийц, бүтээц, эдлэхүүн, материал, түүхий эдийн бат бэх чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох, баталгаажуулалт, аюулгүйн тэмдэг, стандарт, техникийн зохицуулалт, тэдгээрийн үйл ажиллагааг хангах болон лабораториудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах; ✓ барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг шинээр болон шинэчлэн боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах; ✓ яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах.
6	Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	✓ Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах; Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх; ✓ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, ногоон хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах; ✓ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах; ✓ Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж өгөх; ✓ Бусад бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах; ✓ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах; ✓ Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтэд үнэлгээ хийх; ✓ Салбарын эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; ✓ Аймаг, орон нутаг, салбарын төрийн бус байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах;

		✓ Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах; ✓ Байгууллагын ил тод байдлын түвшний үнэлгээ хийх; ✓ Шилэн дансны хөтлөлтөд үнэлгээ хийх; ✓ Яам, харьяа байгууллага, салбарын чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлж байгаа бусад байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган тайлагнаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх; ✓ Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган тайлагнаж эрсдэлээс урьдчилан сэргийлэх; ✓ Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулж мэргэжлийн зөвлөгөө, удирдамжаар хангах; ✓ Нэгжийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, хянах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянан баталгаажуулах, хэрэгжилтийг хангуулах, үнэлэх, дүгнэх; ✓ Иргэд, албан байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, судлан шийдвэрлэх; ✓ Хариуцсан салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, цаашдын бодлого, хөгжлийн стратегийг тодорхойлох, Улсын Их Хурал, Засгийн газар, бодлогын бусад баримт бичигт тусгуулах, дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах; ✓ Салбарын хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлт боловсруулах, хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт шалгалтын нэгдсэн мэдээллийг цахим системийн бүртгэлд хяналт тавьж, баталгаажуулах; ✓ Хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ, шалгалтад хамруулах давтамж, улсын байцаагчдын жилийн ажлын хөдөлмөрийн жишиг норматив, зарцуулах хугацаа зэргийг харгалзан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хууль болон энэ журамд заасны дагуу боловсруулан эрх бүхий байгууллагад хүргүүлэх, батлагдсан даруйд олон нийтэд нээлттэй мэдээлнэ; ✓ Хяналт шалгалтын дүнг үндэслэн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох болон салбарын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан шийдвэрлүүлэх; ✓ Салбарт үүссэн онцгой нөхцөл байдалд зохих журмын дагуу ажиллах; ✓ Улсын (ахлах) байцаагчийн боловсруулсан хяналт шалгалтын баримт бичиг болон албан бичгийг хянаж, хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгөх; ✓ Шаардлагатай тохиолдолд салбарын ерөнхий байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, шалгалтын ажлын хэсэгт орж ажиллах, хяналт шалгалтын баримт бичиг үйлдэх;
--	--	---

		✓ Хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих; ✓ Улсын (ахлах) байцаагчийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд түүнийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх, эсхүл тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, барилгын үйл ажиллагааг бүрмөсөн зогсоох тухай санал, дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; ✓ Хариуцсан салбарын улсын (ахлах) байцаагчдын гаргасан хяналт шалгалтын баримт бичиг болон хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбогдуулан иргэн, ААНБ-аас ирсэн гомдлыг хянан шийдвэрлэх; ✓ Салбарын ерөнхий байцаагчийн нийтлэг чиг үүрэг болон хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасан өдөр тутмын бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх; ✓ Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих хууль, журмын дагуу хэрэгжүүлэх, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтны бүрэн эрхийг хэрэгжүүлэх; ✓ Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавихад, удирдлага зохион байгуулалтаар хангах; ✓ Салбарын улсын (ахлах) байцаагчдын мэдлэг, ур чадварын түвшин, сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд тулгуурлан сургалтын жилийн төлөвлөгөөнд саналаа тусгуулах; ✓ Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу болон бусад арга хэлбэрээр улсын байцаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах; ✓ Сургалтын хөтөлбөр батлах, гарын авлага, зөвлөмж, мэдээллээр хангаж, үр дүнг тооцох; ✓ Улсын байцаагчийн эрх олгуулах, цуцлуулах асуудлыг судлан үзэж, шийдвэрлүүлэх; ✓ Нэгжийн улсын байцаагчдын улирал, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлд хяналт тавих; ✓ Улсын байцаагчдын хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгөх; ✓ Салбарын төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах; ✓ Удирдлагыг өөрийн эрхэлсэн асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, түүний ажилд мэргэжил, арга зүй, удирдлага зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;
--	--	--